

## **Монгол Улс хүний эрхэд суурилсан, бие даасан, хараат бус хууль зүйн тогтолцоонд шилжих хүчин чармайлтаа нэгтгэх ёстой**

УЛААНБААТАР хот (2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр) – Монгол Улс 1992 онд ардчилсан нийгэмд шилжсэнээс хойш шүүх тогтолцооныхоо бие даасан байдлыг сайжруулахын тулд авч хэрэгжүүлсэн алхмуудыг, ялангуяа олон улсын байгууллагуудаас гаргасан хүний эрхийн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр хийсэн ажлуудыг НҮБ-ын шинжээч сайшаав.

“Монгол Улс эхлүүлсэн өөрчлөлтөө дуусгахын тулд энэ мөчийг ашиглах хэрэгтэй” гэж Шүүгч, хуульчдын хараат бус байдлын асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай илтгэгч Хатагтай Маргарет Саттертвэйт тус улсад хийсэн албан айлчлалынхаа төгсгөлд хэллээ. Тэрээр “Монгол Улс нотолгоонд суурилсан шинэчлэл хийж буйг би дэмжиж байгаа ба хүний эрхэд суурилсан, хараат бус хууль зүйн тогтолцоог бэхжүүлэхийн тулд цаашдын алхамуудыг авч хэрэгжүүлэхийг уриалж байна” гэв.

Тусгай илтгэгч нь Улаанбаатар хот, Сэлэнгэ аймаг, Мандал сум, Багануур дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй шүүхүүд болон прокурорын газруудаар орж, ажил үйлстээ бие сэтгэлээ зориулж яваа хууль эрхзүйн мэргэжилтнүүдтэй уулзсан. Хөрөнгө оруулалт дутмагаас шүүгч, ажилтнууд, шүүхээр үйлчлүүлэгсэдэд зориулсан барилга байр хангалтгүй, хүртээмжгүй, аюулгүй байдал хангагдаагүй зэрэг нь хууль зүйн тогтолцоонд ямар хор хөнөөлтэй нөлөө үзүүлж байгааг хатагтай Саттертвэйт өөрийн нүдээр харав. “Монголын шүүгчдийн цалин бага, ажлын ачаалал их юм,” гэж НҮБ-ын шинжээч хэлэв. Тэрээр мөн “Шүүгчид болон шүүгчийн туслахууд ийм хүнд нөхцөлд хэдий ч мэргэжилдээ үнэнчээр ажиллаж байгааг нь үнэлэх хэрэгтэй” гэв.

Шүүх засаглалынхаа ирээдүйг баталгаажуулахын тулд Монголын төр бодитой санхүүжилт хийх хэрэгтэй байгаа тул улсын төсвийн тодорхой хувийг хууль зүйн тогтолцоонд зориулдаг болохыг хатагтай Саттертвэйт уриалав.

Шүүх эрх мэдлийг бэхжүүлэх чиглэлээр хийсэн шинэчлэлтэй дүйцэхүйц арга хэмжээг одоо прокурорын байгууллагад авч хэрэгжүүлэх ёстой. “Прокурорыг томилох, шилжүүлэх, албан тушаал ахиулахад бодитой, ил тод үндэслэлд тулгуурладаг байх ёстой” гэж Тусгай илтгэгч хэлэв. “Үүнээс гадна, прокурорын сахилга бат, хариуцлагыг хангадаг бие даасан байгууллага байгуулах хэрэгтэй” гэв.

Иргэний нийгмээс шүүхийн бие даасан байдалд үнэлгээ, хяналт шинжилгээ хийж байгаа ажлыг Тусгай илтгэгч сайшаав. Тэрээр судалгааны дүнгээр олон нийтийн шүүхэд итгэх итгэл сул байгаад, мөн иргэд, тэр дундаа зарим төрийн албан тушаалтнууд, нийгмийн сүлжээгээр шүүгчдийг гутаан доромжилж байгааг сонсоод сэтгэл зовниж буйгаа илэрхийлэв. “Олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг сэргээх арга хэмжээг төрөөс зайлшгүй авах шаардлагатай байна” гэж хатагтай Саттертвэйт хэлэв. “Хүн бүр тэгш оролцох боломжтой шударга тогтолцоог бүрдүүлэхэд шүүх ямар чухал үүрэг гүйцэтгэж байгааг илүү сайн тайлбарлах боломж Засгийн газарт байна..”

Монголын төр бүх иргэдийнхаа эрхийг хамгаалах, ялгаварлан гадуурхахгүйгээр шударга ёсыг хангах үүрэгтэй гэдгийг Хатагтай Саттертвэйт тэмдэглэв. Тэрээр “Шударга ёсны хүртээмжийг хөдөөгийн малчид, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ЛГБТИК хүмүүс зэрэг тодорхой бүлгийн иргэдэд нэмэгдүүлэхийн тулд иргэний нийгмийн байгууллагуудын хийж буй чухал ажлыг дэмжиж, дэмнэж байхыг би уриалж байна” гэв.

Тусгай илтгэгч айлчлалын дүгнэлт зөвлөмж бүхий тайлангаа НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд 2024 оны 6 дугаар сард танилцуулна.

ТӨГСӨВ.

Мэдэгдлийн бүрэн эхийг [эндээс](#) уншина уу.

**Хатагтай Маргарет Саттертвэйт нь [Шүүгч, хуульчдын хараат бус байдлын асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай илтгэгч юм.](#) Тэрээр Шүүгч, хуульчдын хараат бус байдлын асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай илтгэгчээр 2022 оны 10 дугаар сард Хүний эрхийн зөвлөлийн шийдвэрээр томилогдсон. Профессор М.Саттертвэйт нь хүний эрхийн чиглэлээр мэргэшсэн олон улсын судлаач, олон жилийн дадлага туршлагатай шинжээч юм. Тэрээр Нью-Йоркийн Их сургуулийн Хуулийн сургуулийн Хууль зүйн ухааны профессор юм.**

Тусгай илтгэгчид нь Хүний Эрхийн Зөвлөлийн Тусгай журам хэмээн нэрлэгддэг үйл ажиллагааны нэг хэсэг юм. НҮБ-ын Хүний эрхийн тогтолцооны хараат бус шинжээчдийн хамгийн том тогтолцоо болох Тусгай журам нь дэлхийн өнцөг булан бүрт тодорхой улс орны нөхцөл байдал эсвэл сэдэвчилсэн асуудлуудын талаар хараат бусаар баримт мэдээлэл цуглуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий Хүний эрхийн Зөвлөлийн механизмын ерөнхий нэр юм. Тусгай журмыг хэрэгжүүлэгч шинжээчид нь сайн дурын үндсэн дээр ажилладаг. Тэд НҮБ-ын ажилтан биш бөгөөд НҮБ-аас цалинждаггүй. Тэд аливаа Засгийн газар, ямар нэгэн байгууллагаас хараат бус, бие даасан байдлаар ажилладаг.

НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын газрын вэбсайт дахь Монгол Улсын талаарх мэдээлэл: - [Mongolia](#)

Нэмэлт мэдээлэл болон хэвлэл мэдээллийн хүсэлт байгаа бол дараах хаягаар хандана уу:

[hrc-sr-independencejl@un.org](mailto:hrc-sr-independencejl@un.org)

НҮБ-ын хараат бус шинжээчидтэй холбоотой хэвлэл мэдээллийн лавлагааг дараах ажилтнуудтай холбогдож авна уу: Maya Derouaz ([maya.derouaz@un.org](mailto:maya.derouaz@un.org)), Dharisha Indraguptha ([dharisha.indraguptha@un.org](mailto:dharisha.indraguptha@un.org)).

НҮБ-ын хараат бус шинжээчидтэй холбоотой мэдээг авахыг хүсч байвал дараах Twitter хуудсын дагагч болно уу [@UN\\_SPEXperts](#).

*Concerned about the world we live in?*

*Then STAND UP for someone's rights today.*

*#Standup4humanrights*

*and visit the web page at <http://www.standup4humanrights.org>*

---